



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2023 оны 06 сарын 26 өдөр

Дугаар А/504

Булган сум

**Хөрөнгө гаргах тухай**

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.2, 66 дугаар зүйлийн 66.1, аймгийн ИТХ-ын Хуралдааны 2021 оны III/02 дугаар тогтоолын 4.6.6, аймгийн Засаг даргын 2023 оны А/112 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. "Хөдөөгийн сэргэлт", "Нээлттэй Булган" хөтөлбөрийн хүрээнд хотоос хөдөөрүү шилжин ирж ажиллаж байгаа иргэдийн хандлагыг нэмэгдүүлэх зорилгоор Хутаг-Өндөр суманд эрчимжсэн аж ахуй эрхэлж буй "Занаду Разаорбак" ХХК-ийн захирал Жереми Тиссений бизнесийн үйл ажиллагааг түгээх контентийг бэлтгэхэд шаардагдах 1,720,000 (нэг сая долоон зуун хорин мянга) төгрөгийг "Чинээлэг малчин" хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний зардлаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Д.Алтаншагай)-д зөвшөөрсүгэй.

2. Тус контентод аймгийн эрчимжсэн аж ахуй, газар тариалан эрхлэгчдийг хамруулж, бэлтгэл хангаж ажиллахыг аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газар (Ч.Амгалан)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Б.АРИУН-ЭРДЭНЭ



6323010508